Тандэм Инвэст ББСБ
Хувьцаат компани

# 2025 ОНЫ
# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
# ТАЙЛАН

"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК

УЛААНБААТАР ХОТ 2026 ОН

# Агуулга


| | |
|---|---|
| **КОМПАНИЙН ТУХАЙ** | КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ<br>КОМПАНИЙН АЖИЛЧИД, СУРГАЛТ |
| **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА** | КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА<br>ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА<br>НООГДОЛ АШГИЙН БОДЛОГО |
| **САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ** | КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ<br>КОМПАНИЙН АШИГТ АЖИЛЛАГАА, ӨГӨӨЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ |
| **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ** | КОМПАНИЙН ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨЛӨВЛӨГӨӨ<br>ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ, ХУРЛЫН ИРЦ |

# Компанийн үйл ажиллагаа

Хувьцааны тоо
2,000,000,000

Үйл ажиллагааны төрөл
3

Бүтээгдэхүүн
9

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
6,040,000,000

Харилцагчдийн тоо
1,169

Зээлийн багц
34,581,151,377.58

Программ хангамж
Спинел 6.0

Ажилчид
16

# Зээлийн үйл ажиллагаа

## Зээлийн багцийн ангилал




## Зээлийн багцын чанар



# Зээлийн үйл ажиллагаа

## ОЛГОСОН ЗЭЭЛ

ХАМРАХ ХУГАЦАА **5 ЖИЛ**

CAGR **41.4%**




## ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ТОО

ХАМРАХ ХУГАЦАА **5 ЖИЛ**

CAGR **1.2%**



# “ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА




"Тандэм инвэст ББСБ" ХК нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Тандэм Инвэст ББСБ" ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.10 дахь заалт, Ногдол ашгийн журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 01 дугаар тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны цэвэр ашиг болох 4,617,347,556 төгрөгөөс компанийн хувьцаа эзэмшигчдэд 2,600,000,000 төгрөгийг, нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.30 (нэг төргөр гучин мөнгө) төгрөгөөр тооцон хуваарилахаар шийдвэрлэжээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

FIN AZ AUDIT

ФИН АЗ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Энх тайвны өргөн, Экспресс тауэр 1503 тоот
Утас/Факс: 976-99104222, E-mail: finazaudit@gmail.com

2026-02-16 № А04/26

танай ____________ -ны № ____________ -т

**"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК –ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуй, санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр "ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

**Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

ФИН АЗ АУДИТ ХХК
FIN AZ AUDIT

"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК

2025 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| Үзүүлэлт | Тодруулга | 2025.01.01 | 2025.12.31 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 1 | 2,736,633,073 | 4,653,507,716 |
| Зээл | 2 | 27,492,936,970 | 32,645,686,236 |
| Факторингийн тооцооны авлага | | | |
| Үүсмэл санхүүгийн хөрөнгө | | | |
| Хөрөнгө оруулалт | | | |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | | |
| **Санхүүгийн хөрөнгийн дүн** | | **30,229,570,043** | **37,299,193,952** |
| Татвар, НДШ -ийн авлага | | | |
| Үндсэн хөрөнгө | 3 | 749,035,756 | 596,905,976 |
| Биет бус хөрөнгө | 4 | 2,434,082 | 2,773,760 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | | |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 5 | 20,048,908 | 451,840,017 |
| **Санхүүгийн бус хөрөнгийн дүн** | | **771,518,747** | **1,051,519,752** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **31,001,088,790** | **38,350,713,704** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр | 6 | 5,073,715,404 | 9,948,471,851 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | | | |
| Бусад эх үүсвэр | | | |
| Үүсмэл санхүүгийн өр төлбөр | | | |
| Бусад санхүүгийн өр төлбөр | | | |
| Хоёрдогч өглөг | | | |
| Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр) | | | |
| Санхүүгийн өр төлбөрийн дүн | | 5,073,715,404 | 9,948,471,851 |
| Татвар, НДШ -ийн өр төлбөр | 7 | 311,824,232 | 396,910,970 |
| Нөөц /Болзошгүй өр төлбөр / | | | |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | | | |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 8 | 321,261 | 48,306,947 |
| Санхүүгийн бус өр төлбөрийн дүн | | 312,145,493 | 445,217,917 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | | **5,385,860,896** | **10,393,689,768** |
| **ӨМЧ** | | | |
| Хувьцаат капитал | 9 | 4,600,000,000 | 6,040,000,000 |
| Халаасны хувьцаа | 10 | -3,569,520 | -3,569,520 |
| Нэмж төлөгдсөн капитал | 11 | 17,288,693,694 | 17,288,693,694 |
| Өмчийн бусад хэсэг | | | |
| Хуримтлагдсан ашиг, (алдагдал) | 12 | 3,730,103,720 | 4,631,899,762 |
| **НИЙТ ӨМЧИЙН ДҮН** | | **25,615,227,894** | **27,957,023,937** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **31,001,088,790** | **38,350,713,704** |

*Нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.*



ФИН АЗ АУДИТ ХХК
FIN AZ AUDIT

# Санхүүгийн тайлагнал

Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, нэмэлт тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлт гаргасан. Дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /"СТОУС"/-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

| Балансын зүйл | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 17,533,629,359.00 | 20,596,490,525.00 | 30,229,570,043 | 37,299,193,952 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 488,384,829.00 | 444,348,917.00 | 771,518,747 | 1,051,519,752 |
| Нийт хөрөнгө | 18,022,014,188.00 | 21,040,839,442.00 | 31,001,088,790 | 38,350,713,702 |
| Өр төлбөр | 3,765,578,003.00 | 5,471,305,393.00 | 5,385,860,896 | 10,393,689,768 |
| Энгийн хувьцаа | 3,468,668,428.00 | 3,468,668,428.00 | 4,600,000,000.00 | 6,0440,000,000 |
| Халаасны хувьцаа | -3,569,520.00 | -3,569,520.00 | -3,569,520.00 | -3,569,520.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | 8,779,112,743.00 | 8,779,112,743.00 | 17,288,693,694.00 | 17,288,693,694.00 |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал/ | 2,012,224,534.00 | 3,325,322,398.00 | 3,730,103,720 | 4,631,899,762 |
| Эздийн өмч | 14,256,436,185.00 | 15,569,534,049.00 | 25,615,227,894 | 27,957,023,937 |
| Өр төлбөр ба эздийн өмчийн дүн | 18,022,014,188.00 | 21,040,839,442.00 | 31,001,088,790 | 38,350,713,704 |

# Санхүүгийн тайлагнал

Нийт орлого, ашиг | сая ₮



# Санхүүгийн тайлагнал

Өгөөжийн үзүүлэлт




Цэвэр ашгийн хувь



# Компанийн засаглал






| Нэрс | Хурлын ирц | Мэдээлэл | Хувьцаа эзэмшигч эсэх |
|---|---|---|---|
| Ч.Чинзориг | 100% | ТУЗ-ийн дарга | Тийм |
| Ч.Лодойравсал | 100% | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Үгүй |
| Б.Энх-Амгалан | 100% | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Үгүй |
| А.Даваадорж | 100% | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Үгүй |
| Ц.Билэг-Өрнөх | 100% | ТУЗ-ийн гишүүн | Тийм |
| Ч.Тэмүдэр | 100% | ТУЗ-ийн гишүүн | Тийм |
| П.Чинзориг | 100% | ТУЗ-ийн гишүүн | Тийм |
| Л.Очирмаа | 100% | ТУЗ-ийн гишүүн | Тийм |
| Ч.Бадмаараг | 100% | ТУЗ-ийн гишүүн | Тийм |

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

- Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нэмэгдэж хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсноор компанийн дүрэм шинэчлэгдсэн бөгөөд үүнээс дурдвал нэг бүр нь 3.02 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000,000,000 ширхэг гаргасан энгийн хувьцаатай, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6,040,000,000 төгрөг болж нэмэгдсэн.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 3-р сарын 21-ны өдрийн
- 3/1066 тоот тогтоолоор хэрэглээний зээл олгох зохицуулалтад
- хамаарах харьцааг бууруулж, өр орлогын харьцааг тус тус 60 хувиас ихгүй байхаар тогтоосны дагуу Компанийн зээлийн үйл ажиллагааны нөхцөлд өөрчлөлт оруулсан.
- 2024 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгосон.
- Тайлант хугацаанд 971 хувьцаа эзэмшигчдэд 2,200,000,000 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан.
- Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчилсэн.
- 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулсан.
- Компанийн бүтцийг шинэчлэн баталсан.
- Компанийн итгэлцлийн үйлчилгээний нөхцөлийг шинэчлэн баталсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, дэргэдэх хороод, нарийн бичгийн даргыг сонгон томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл удирдлагын хорооны журмыг шинэчлэн баталсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ээлжит хурлын хуваарь баталсан.
- Компанийн бизнес төлөвлөгөөг баталсан.
- Компанид хөрөнгө худалдан авах тухай хэлэлцэн баталсан.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11-р сарын 3-ны өдрийн 16 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгийг чөлөөлж, Б.Мандхайг томилсон.
- Компанийн зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нөхцөлийг шинэчлэн баталсан.
- Компанийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн байгууллагаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 11-р сарын 18-ны өдрийн 18 тоот тогтоолоор “Фин Аз Аудит” ХХК-ийг сонгосон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хорооны даргыг шинээр томилсон.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хорооны журам, Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөрийг хэлэлцэн баталсан.

# ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

| Төлөөлөн удирдах зөвлөл | ТУЗ-ийн дэргэдэх хороод | ТУЗ-ийн нарийн бичиг |
|---|---|---|
| 1. Б.Энх-Амгалан | 1. Ц.Билэг-Өрнөх | 1. П.Чинзоиг |
| 2. Ц.Билэг-Өрнөх | 2. Ц.Билэг-Өрнөх | 2. А.Даваазориг |
| 3. Ч.Лодойравсал | 3. Ч.Лодойравсал | 3. Б.Энх-Амгалан |

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд нийт 10 удаа хуралдаж нийт 21 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод тус бүр 1 удаа хуралдаж Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилтаас өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн дагуу холбогдох журмуудыг шинэчлэн баталсан байна.

Компанийн 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл ажлыг хангаж Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журам”-ийн дагуу зохион байгуулах бүх шатны бэлтгэл ажлыг хийсэн бөгөөд хурлыг дүрэм журмын дагуу зөрчилгүй, ил тод, нээлттэй зохион байгуулж ажилласан байна. Мөн ТУЗ-ийн хурлын материал бэлтгэх, гишүүдэд урьдчилан хүргэх ажлыг зохион байгуулж, ТУЗ болон хороодоос гарсан тогоолыг холбогдох хууль журмын дагуу олон нийтэд тайлагнасан.

Тандэм Инвэст ББСБ
Хувьцаат компани

# ТАНД ДЭМ

info@tandem.mn
70151510
facebook.com/Tandem Invest NBFI
www.tandem.mn